# МОНГОЛ УЛС
# ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2016 оны 5 дугаар сарын 6 -ны өдөр | Дугаар 50 | Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хариуцагч болон хамтран хэрэгжүүлэгч талуудын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангаж, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан, биелэлтийг жил бүрийн нэгдүгээр улиралд танилцуулж байхыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга /бригадын генерал Т.Бадрал/-д даалгасугай.

Монгол Улсын Шадар сайд Ц.ОЮУНБААТАР

Монгол Улсын Шадар сайдын
2016 оны 50 дугаар тушаалын
хавсралт

# ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТОЙ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2016-2025/

<table>
<tr><th rowspan="2">№</th><th rowspan="2">Хэрэгжүүлэх арга хэмжээ</th><th rowspan="2">Хариуцах байгууллага</th><th rowspan="2">Хамтран хэрэгжүүлэгч</th><th colspan="6">Хугацаа, хүрэх үр дүн</th></tr>
<tr><th>I үе шат 2016-2020 он</th><th colspan="2">Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн</th><th>II үе шат 2021-2025 он</th><th colspan="2">Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн</th></tr>
<tr><td colspan="10">Нэг.“Олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн орчин, тогтолцоог бүрдүүлэх” зорилтын хүрээнд</td></tr>
<tr><td rowspan="2">1.1</td><td rowspan="2">Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хэрэглэгч, олон нийтийн оролцоог хангах эрх зүйн орчинг бүрдүүлэх, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах</td><td rowspan="2">ОБЕГ</td><td rowspan="2">ХЗЯ, Иргэний нийгмийн байгууллага</td><td rowspan="2">2016-2020</td><td>1</td><td>Гамшгаас хамгаалах хууль тогтоомжид иргэдийн оролцоо, эрх, үүргийн талаар тусcан байх</td><td rowspan="2"></td><td rowspan="2">1</td><td rowspan="2">Гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагаанд олон нийтийн идэвх, оролцоо төлөвшсөн байх</td></tr>
<tr><td>2</td><td>Олон нийтийн оролцоог хангах талаар журам, дүрэм, заавар боловсруулж гаргасан байх</td></tr>
<tr><td rowspan="3">1.2</td><td rowspan="3">Нутгийн иргэдэд түшиглэн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх тогтолцоог бүрдүүлэх</td><td rowspan="3">ОБЕГ</td><td rowspan="3">Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэний нийгмийн байгууллага</td><td rowspan="3">2016-2020</td><td>3</td><td>Эрсдэлийн үнэлгээ хийх эрх зүйн орчин бүрдсэн байх.</td><td rowspan="3">2021-2025</td><td rowspan="2">2</td><td rowspan="2">Иргэдэд эрсдэлийн үнэлгээ хийх мэдлэг, чадвар олгох асуудал тасралтгүй явагддаг болсон байх.</td></tr>
<tr><td>4</td><td>Нутгийн иргэд эрсдэлийн үнэлгээ хийх мэдлэг, чадвартай болсон байх</td></tr>
<tr><td>5</td><td>Эрсдэлийн үнэлгээ хийх эрх бүхий байгууллага чадавхжсан байх</td><td>3</td><td>Эрх бүхий байгууллага, иргэдийн хамтын ажиллагаа тогтсон байх.</td></tr>
<tr><td rowspan="3">1.3</td><td rowspan="3">Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөлтөд хэрэглэгч, олон нийтийн оролцоог хангах нөхцлийг бүрдүүлэх</td><td rowspan="3">ОБЕГ</td><td rowspan="3">Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэний нийгмийн байгууллага</td><td rowspan="3">2016-2020</td><td>6</td><td>330 сум, нийслэлийн гамшгийн аюулт үзэгдэл, ослын судалгааг гаргасан байх</td><td rowspan="3"></td><td rowspan="2">4</td><td rowspan="2">Орон нутгийн хэмжээнд гамшгийн талаарх нэгдсэн судалгаатай болсон байх</td></tr>
<tr><td>7</td><td>Гамшгаас хамгаалах төлөвлөлтийн чиглэлээр иргэдийг сургаж бэлдсэн байх</td></tr>
<tr><td>8</td><td>Олон нийтийн санал бодлыг төлөвлөлтөд тусгах, хамтран боловсруулж хэвшсэн байх</td><td>5</td><td>Олон нийтийн оролцоонд тулгуурлаж гамшгаас хамгаалах төлөвлөлтийг хийдэг болсон байх</td></tr>
</table>

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч | Хугацаа, хүрэх үр дүн | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | I үе шат 2016-2020 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | | II үе шат 2021-2025 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | |
| | | | | | 9 | Төлөвлөгдсөн арга хэмжээ, шаардагдах зардал олон нийтэд ил тод байх | | 6 | Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг олон нийт өөрсдөө төлөвлөж хэрэгжүүлдэг болсон байх |
| 1.4 | Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг холбогдох бодлого, эрх зүйн баримт бичигт тусгаж хэрэгжүүлэх | ОБЕГ | БОНХАЖЯ, ХЗЯ | 2016-2018 | 10 | Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тусгасан байх | | 7 | Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох чиглэлээр гарах үндэсний стратеги, хөтөлбөрт тусгасан байх |
| | | | | | 11 | Сендайн хүрээний баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөөнд тусгасан байх | | | |
| Хоёр.**"Гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн сургалт, сурталчилгааг бүх түвшинд шат дараалан зохион байгуулах"** зорилтын хүрээнд | | | | | | | | | |
| 2.1 | Иргэд, хэрэглэгчдэд гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг олгох нөхцлийг бүрдүүлэх, сургалт, сурталчилгааг төлөвлөж хэрэгжүүлэх | ОБЕГ | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэний нийгмийн байгууллага, иргэд | 2016-2020 | 1 | Иргэдийг сургах сургалт, мэдээллийн төвийг 5 бүсэд байгуулсан байх | | 1 | Сургалт, сурталчилгаа хийх төлөвлөгөөг жил бүр гаргаж баталсан байх |
| | | | | | 2 | Сургалтын хэрэглэгдэхүүн, ном, гарын авлага гаргасан, сургах чиглэлийг тодорхойлсон, шаардагдах зардлыг төсөвлөсөн байх | | 2 | Сургагч багш нарыг үе шаттай чадавхжуулж шаталсан сургалтад хамруулсан байх |
| | | | | | 3 | Сум бүр 2-оос доошгүй сургагч багшийг сургаж бэлтгэсэн байх | | 3 | Иргэдийн идэвх, оролцоо бүрдсэн байх |
| 2.2 | Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бүлэг, нөхөрлөл, иргэдэд гамшгийн эрсдэлийг бууруулах сургалт, сурталчилгааг шат дараатай явуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх | БСШУЯ, Аймаг, нийслэлийн Засаг дарга ОБЕГ | Улсын болон орон нутгийн албад, иргэний нийгмийн байгууллага, иргэд | 2016-2020 | 4 | Мэргэжил, арга зүйн дэмжлэг нь хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх | 2021-2025 | 4 | Аж ахуйн нэгж, байгууллага, бүлэг, нөхөрлөлүүдийн 40 хувь нь өөрсдөө бие дааж сургалтыг тасралтгүй явуулах нөхцөл бүрдсэн байх |
| | | | | | 5 | Аж ахуйн нэгж, байгууллага, бүлэг, нөхөрлөлийн сургалт жилд 2-оос доошгүй удаа тогтмол явагддаг болсон байх | | | |
| 2.3 | Гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэгийг хэрэглэгч, олон нийтэд олгох, | ХАХНХЯ, БСШУЯ, СЯ, ХЯ, ОБЕГ, МТШХХГ | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага | 2016-2020 | 6 | Нийгмийн эмзэг хэсгийнхний хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагыг судалсан байх | | 5 | Гамшгийн эрсдэлийг бууруулахад нийгмийн эмзэг хэсгийнхний оролцоо, нэмэгдсэн, тэдний мэдлэг, чадавх сайжирсан байх |
| | | | | | 7 | Эмэгтэйчүүд, нийгмийн эмзэг хэсгийнхний эрх ашгийг хамгаалах байгууллагуудтай хамтарч | | 6 | Иргэдэд эрсдэлгүй |

<table>
<tr><th rowspan="2">№</th><th rowspan="2">Хэрэгжүүлэх арга хэмжээ</th><th rowspan="2">Хариуцах байгууллага</th><th rowspan="2">Хамтран хэрэгжүүлэгч</th><th colspan="6">Хугацаа, хүрэх үр дүн</th></tr>
<tr><th>I үе шат 2016-2020 он</th><th colspan="2">Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн</th><th>II үе шат 2021-2025 он</th><th colspan="2">Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн</th></tr>
<tr><td rowspan="5"></td><td rowspan="5">эрсдэлгүй зан үйлийг хэвшүүлэх, эмэгтэйчүүдийг чадавхижуулах, сургалт, сурталчилгааг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, өндөр настан, амьжиргааны түвшин доогуур орлоготой иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тохирсон арга барилаар зохион байгуулах</td><td rowspan="5"></td><td rowspan="5"></td><td rowspan="5"></td><td></td><td>ажиллах чиглэлээр гэрээ, санамж бичиг байгуулсан байх</td><td rowspan="5"></td><td></td><td>амьдрах ухаан, зан үйл тогтсон байх</td></tr>
<tr><td>8</td><td>Зорилтот бүлэгт тохирсон сургалтын арга хэлбэрийг тодорхойлсон байх</td><td>7</td><td>Иргэдийн гамшгийн эрсдэлд өртөх байдал багассан байх</td></tr>
<tr><td>9</td><td>Сургалтыг зорилтот бүлгийнхэнтэй хамтарч, жилд 1-ээс доошгүй удаа тэдний оролцоотой зохион байгуулж хэвшсэн байх</td><td rowspan="2">8</td><td rowspan="2">Эмэгтэйчүүдийн гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаан дахь манлайлал өссөн байх</td></tr>
<tr><td>10</td><td>Иргэдэд эрсдэлгүй амьдрах ухаан, зан үйлийг хэвшүүлэх чиглэлээр ТВ-ийн нэвтрүүлэг, сонин сэтгүүл гаргаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж хэвшсэн байх</td></tr>
<tr></tr>
<tr><td rowspan="3">2.4</td><td rowspan="3">Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, хүүхэд, сайн дурынхан, залуучуудад зориулсан ном, гарын авлага, заавар, зөвлөмж сэрэмжлүүлэг, дүрс бичлэгийн богино хэмжээний кино, цахим сургалт, гар утасны программ хийх, үзүүлэн таниулах болон тараах материал бэлтгэж нийтэд түгээх</td><td rowspan="3">ОБЕГ, МТШХХГ</td><td rowspan="3">Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэд</td><td rowspan="3">2016-2020</td><td>11</td><td>Иргэд, олон нийтийн эрэлт, хэрэгцээ, насны онцлог, нийгмийн байдалд нь нийцсэн байх</td><td rowspan="3">2021-2025</td><td rowspan="2">9</td><td rowspan="2">Цахим болон зайн сургалтын орчин бүрдсэн байх</td></tr>
<tr><td>12</td><td>Олон нийтийн оролцоонд тулгуурлаж хийгдсэн байх</td></tr>
<tr><td>13</td><td>Иргэд, олон нийтэд хүртээмжтэйгээр /хүн амын 50 хувь/ түгээсэн байх</td><td>10</td><td>Үүрэн холбооны операторуудын цахим сүлжээнд нэвтэрсэн байх</td></tr>
<tr><td rowspan="3">2.5</td><td rowspan="3">Зэвсэгт хүчин, Хил хамгаалах болон Цагдаагийн байгууллага, гэрээт болон дүйцүүлэх албаны цэргийн албан хаагч нарт ой, хээрийн түймэр, хүн малын гоц халдварт өвчинтэй тэмцэх</td><td rowspan="3">ОБЕГ</td><td rowspan="3">ЗХЖШ<br>ХХЕГ<br>Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга,<br>Цэргийн штаб, иргэний нийгмийн</td><td rowspan="3">2016-2020</td><td>14</td><td>Жилд 1-ээс доошгүй удаа сургалт явуулсан байх</td><td rowspan="3"></td><td rowspan="3">11</td><td rowspan="3">Хилийн бүс орчим гарах түймрийн тоо буурсан байх</td></tr>
<tr><td>15</td><td>Хамтарсан дадлага, сургуулийг жилд 1-ээс доошгүй удаа хийсэн байх</td></tr>
<tr><td>16</td><td>Алба хаагч, гэрээт болон</td></tr>
</table>

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч | Хугацаа, хүрэх үр дүн | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | I үе шат 2016-2020 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | | II үе шат 2021-2025 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | |
| | чиглэлээр сургалт зохион байгуулах | | байгууллага | | | дүйцүүлэх цэргийн албан хаагчдын гамшигтай тэмцэх мэдлэг, чадвар дээшилсэн байх | | 12 | Онцгой байдлын алба, Зэвсэгт хүчин, Хил хамгаалах болон Цагдаагийн байгууллагын гамшигийн үеийн харилцан ажиллагаа тогтсон байх |
| | | | | | 17 | Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагууд ой, хээрийн түймэртэй тэмцэх техник, хэрэгслийг бүрдүүлсэн байх | | | |
| 2.6 | Гамшгийн эрсдэлийг бууруулах талаар нийтийг хамарсан арга хэмжээ, аян өрнүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, иргэний үүсгэл, санаачилга, ололт амжилт, тэргүүн туршлагыг сурталчлан таниулах, урамшуулах | ОБЕГ | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэний нийгмийн байгууллага ААНБ, иргэд | 2016-2020 | 18 | Нийтийг хамарсан арга хэмжээ нь олон нийтийн оролцоонд тулгуурласан байх | 2021-2025 | 13 | Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын талаар олон нийт мэддэг болсон байх |
| | | | | | 19 | Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын 60-аас доошгүй хувьтай нь хамтын ажиллагаатай болсон байх | | | |
| | | | | | 20 | Хэвлэл, мэдээллийн байгууллагаар олон нийтэд хүртээмжтэйгээр сурталчилж таниулсан байх | | 14 | Эдгээр байгууллагын үйл ажиллагаа тогтмолжиж, идэвх оролцоо нэмэгдсэн байх |
| | | | | | 21 | Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын тоо нэмэгдсэн байх | | 15 | Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр төрийн зарим чиг үүргийг шилжүүлсэн байх |
| 2.7 | Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр (X/13)-ийг улсын хэмжээнд жил бүр олон нийтийн оролцоонд тулгуурлан тэмдэглэж хэвших | ОБЕГ | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэний нийгмийн байгууллага | 2016-2020 | 22 | Энэ өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд олон нийтийн идэвх, оролцоо нэмэгдсэн байх | 2021-2025 | 16 | Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, иргэдийг олон нийтэд сурталчлан таниулдаг өдөр болж хэвшсэн байх |
| | | | | | 23 | Төрөл бүрийн арга хэмжээ явагдаж хэвшсэн байх | | | |
| | | | | | 24 | Улсын хэмжээнд нийтээр тэмдэглэдэг болсон байх | | | |
| 2.8 | Гамшгаас хамгаалах эрт зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуулийг жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх долоо хоногийн Пүрэв гаригт улсын хэмжээнд зохион байгуулж хэвших | ОБЕГ | Төрийн байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, ААНБ, иргэний нийгмийн байгууллага, иргэд | 2016-2020 | 25 | Төр, хувийн хэвшлийн бүх байгууллагыг хамарч хийгддэг болсон байх | 2021-2025 | 17 | Иргэд, олон нийт дохиогоор ажиллах мэдлэг, дадлагыг бүрэн эзэмшсэн, дасгал сургуулийг хийж хэвшсэн байх |
| | | | | | 26 | Иргэд, олон нийтийн идэвх оролцоо, мэдлэг, дадлага нэмэгдсэн байх | | | |
| | | | | | 27 | Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд | | | |

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч | Хугацаа, хүрэх үр дүн<br>I үе шат 2016-2020 он | | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | II үе шат 2021-2025 он | | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суртачилж таниулсан байх | | | |
| 2.9 | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл, сурталчилгааг тодорхой давтамжтайгаар хэрэглэгч, олон нийтэд түгээх | ОБЕГ, МТШХХГ | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, хэвлэл мэдээллийн байгууллага (телевиз, FM, радио, үүрэн телефоны операторууд) | 2016-2020 | 28 | Цаг үе, хэрэгцээ шаардлагад нийцсэн байх | 2021-2025 | 18 | Нийт хүн амд сэрэмжлүүлэг мэдээг жигд хүргэх нөхцөл, боломж бүрдсэн байх |
| | | | | | 29 | Хүртээмжтэй, давтамжтай, үлдэцтэй байх | | | |
| | | | | | 30 | Шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой байх | | 19 | Гамшгийн аюулд хохирогсдын тоо, хохирлын хэмжээ буурсан байх |
| | | | | | 31 | Сэрэмжлүүлэг мэдээг иргэд өдөр тутмын ахуй амьдралдаа ашиглаж хэвшсэн байх | | | |
| 2.10 | Гамшгийн эрсдэлийг бууруулах, аюулгүй амьдрах ухааны боловсрол, хүмүүжил олгох хичээлийг сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрт оруулах, сургалтыг хүүхдийн насны онцлогт тохируулан явуулах | БСШУЯ, ОБЕГ | Бүх шатны боловсролын байгууллага | 2016-2020 | 32 | Эрх зүйн орчинг бүрдүүлсэн байх | | 20 | Сургалтын арга зүй оновчтой, үр дүнтэй болсон байх |
| | | | | | 33 | Багш, сурган хүмүүжүүлэгч нар бэлтгэгдсэн байх | | | |
| | | | | | 34 | Ном, сурах бичиг, гарын авлагыг боловсруулж, хүртээмжтэй хэвлэгдэж гарсан байх | | 21 | Хүүхэд, багачуудын аюулгүй амьдрах ухаан, гамшгаас хамгаалах мэдлэг боловсрол дээшилж, гамшигт өртөх байдал буурсан байх |
| | | | | | 35 | Хичээлийн агуулга нь хүүхдийн насны онцлогт нийцсэн байх | | | |
| 2.11. | Их, дээд болон мэргэжлийн боловсролын сургуульд зааж буй гамшгийн менежмент хичээлийн агуулгыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх | БСШУЯ, ОБЕГ | Дээд болон мэргэжлийн боловсролын байгууллага, | 2016-2018 | 36 | Төрийн болон хувийн хэвшлийн сургуулийн 60-аас доошгүй хувийг хамарсан байх | | 22 | Ном, сурах бичиг хүртээмжтэй байх |
| | | | | | 37 | Хичээлийн агуулга нь цаг үе, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх | | | |
| | | | | | 38 | Багшлах боловсон хүчин бэлтгэгдсэн байх | | | |
| 2.12. | Гамшгаас хамгаалах талаарх үндэсний уламжлалт ухааныг сэргээх, мэдлэг мэдээллийг түгээх, сурталчлан таниулах арга хэмжээг хэрэглэгч, олон нийт, ялангуяа ахмад, өндөр настнуудын оролцоотойгоор авч хэрэгжүүлэх | БОНХАЖЯ, ОБЕГ | МТШХХГ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг дарга, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллага | 2016-2020 | 39 | Ахмадуудын мэдлэг, туршлага, ардын уламжлалт ухааныг судалж, ном, товхимол гаргасан байх | 2021-2025 | 23 | Гамшгаас хамгаалах талаарх үндэсний уламжлалт арга ухааны талаар иргэд, олон нийтийн мэдлэг дээшилсэн байх |
| | | | | | 40 | Ардын уламжлалт арга, ухааны талаар сонин сэтгүүлд хэвлэх, ТВ-ийн нэвтрүүлэг, баримтат кино хийсэн байх | | | |

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч | Хугацаа, хүрэх үр дүн | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | I үе шат 2016-2020 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | | II үе шат 2021-2025 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | |
| 2.13. | Хэрэглэгч, олон нийтийн дунд гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг ухуулан таниулах зорилгоор төрөл бүрийн өдөрлөг, уралдаан, тэмцээнийг жил бүр тодорхой сэдвийн дор зохион явуулах | БСШУЯ, ОБЕГ | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэний нийгмийн байгууллага, иргэд | 2016-2020 | 41 | Баг, хорооны түвшинд хууль сурталчлах, гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үе шаттай тэмцээн, уралдаан зохион байгуулсан байх | 2021-2025 | 24 | Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг ухуулан таниулах зорилгоор аймаг, сумын хэмжээнд үе шаттай тэмцээн уралдаан зохион байгуулсан байх |
| | | | | | 42 | Аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд жилд 2-оос доошгүй удаа өдөрлөг, сэдэвт аяныг зохион байгуулсан байх | | | |
| | | | | | 43 | Олон нийтийг өргөнөөр хамруулсан байх | | | |
| 2.14. | Гамшгийн эрсдэлийг бууруулахад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах | БСШУЯ, ОБЕГ, | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэний нийгмийн болон хүүхдийн байгууллага | 2016-2020 | 44 | Эрх зүйн зохицуулалтыг бий болгосон байх | 2021-2025 | 25 | “Өсвөрийн аврагч” клуб, Анхан шатны нөхөрлөлийн үйл ажиллагаа жигдэрсэн байх |
| | | | | | 45 | “Өсвөрийн аврагч” клубуудыг орон нутгийн анхан шатны нэгжийн түвшинд 80-аас доошгүй хувьд байгуулж, сургаж бэлтгэсэн байх | | | |
| | | | | | 46 | Сургуулиудын дунд тэмцээн уралдаан тогтмол зохион байгуулж хэвшсэн байх | | 26 | Гамшгийн эрсдэлийг бууруулахад хүүхдийн идэвх, оролцоог олон нийтэд сурталчилж урамшуулсан байх |
| | | | | | 47 | Хүүхдүүдийн үүсгэл, санаачилгыг дэмжиж, идэвх оролцоог нэмэгдүүлсэн байх | | 27 | Хүүхдийн байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа сайжирсан байх |
| Гурав.**”Олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх”** зорилтын хүрээнд | | | | | | | | | |
| 3.1 | Гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийх арга зүйг иргэдэд зааж, тэдний оролцоотойгоор тухайн орон нутгийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах | ОБЕГ | БСШУЯ, ХАХНХЯ, Хүүхдийн төлөө үндэсний газар, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэний нийгмийн байгууллага, иргэд | 2016-2020 | 1 | Гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийх эрх зүйн орчин бүрдсэн байх | | 1 | Гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг иргэдийн оролцоонд тулгуурлаж хийдэг тогтолцоонд шилжсэн байх |
| | | | | | 2 | Гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийх аргачлалыг боловсруулсан байх | | | |
| | | | | | 3 | Гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийх арга зүйн сургалт орон нутгийн түвшинд зохион байгуулагдсан байх | | | |

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч | Хугацаа, хүрэх үр дүн | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | I үе шат 2016-2020 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | | II үе шат 2021-2025 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | |
| 3.2 | Хэрэглэгч, олон нийтийн оролцоотой гаргасан гамшгийн эрсдэлийн үнэлгээнд тусгагдсан эрсдэлийг бууруулах арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх, энэхүү арга хэмжээнд хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах | ОБЕГ | БСШУЯ, ХАХНХЯ, Хүүхдийн төлөө үндэсний газар, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэний нийгмийн байгууллага, иргэд | | 4 | Үнэлгээнд тусгагдсан эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөсөн байх | | 2 | Үнэлгээнд тусгагдсан эрсдэлийг бууруулах арга хэмжээ хэрэгжсэн байх |
| | | | | | 5 | Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд хэрэглэгч, олон нийтийн идэвхи санаачлага, эмэгтэйчүүдийн манлайлал, бусад зорилтот бүлгийн оролцоо, хүйсийн тэгш байдал зэргийг эрхэмлэсэн байх | | 3 | Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо хэвшиж, хүйсийн тэгш байдал хангагдсан байх |
| 3.3 | Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг тухайн орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулах, шинэчлэх | ОБЕГ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга | Иргэний нийгмийн байгууллага, иргэд | 2016-2020 | 6 | Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаар орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт тусгасан байх | 2021-2025 | 4 | Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавх, бэлтгэл бэлэн байдал дээшилсэн байх |
| | | | | | 7 | Орон нутагт тохиолдож болзошгүй гамшгийн эрсдэл буурсан байх | | 5 | Орон нутгийн хөгжлийн бодлогыг гамшгийн асуудалтай уялдуулж тодорхойлдог болсон байх |
| 3.4 | Сумдад гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд зарцуулах гамшгаас хамгаалах сан, аж ахуйн нэгж, байгууллага, хоршоо, нөхөрлөл, малчид, иргэдийн бүлгийн дунд гамшгийн эрсдэлийг бууруулах дундын хөрөнгийн санг тус тус байгуулахыг дэмжих | ХХААЯ, БОНХАЖЯ, ОБЕГ | УУЯ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ААНБ, иргэд | 2016-2020 | 8 | Хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн байх | | 6 | Сум бүр гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд зарцуулах гамшгаас хамгаалах санг бүрдүүлсэн байх |
| | | | | | 9 | Гамшгийн эрсдэлийг бууруулах дундын хөрөнгийн санг бүрдүүлэх зөвлөмж, гарын авлага боловсруулсан байх | | | |
| | | | | | 10 | Аж ахуйн нэгж, байгууллагуудын 60, иргэд, малчдын бүлгийн 50-аас доошгүй хувь нь гамшгийн эрсдэлийг бууруулах дундын хөрөнгийн санг бүрдүүлсэн байх | | | |

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч | Хугацаа, хүрэх үр дүн | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | I үе шат 2016-2020 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | | II үе шат 2021-2025 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | |
| 3.5 | Гамшгийн эрсдэлийг бууруулах, аюулгүй амьдрах ухаан, зан үйлийг хэвшүүлэх талаар хэрэглэгч, олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулж, санал асуулга, судалгаа хийж, тэдний санал, зөвлөмжийг гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд ашиглах | БСШУЯ, ОБЕГ | БОНХАЖЯ аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэний нийгмийн байгууллага | 2016-2020 | 11 | Гамшгийн эрсдэлийг бууруулах, аюулгүй амьдрах ухаан, зан үйлийн талаар судалгаа хийсэн байх | 2021-2025 | 7 | Иргэдийн дунд аюулгүй амьдрах ухаан, зөв хандлага, зан үйл төлөвшсөн байх |
| | | | | | 12 | Гамшгийн эрсдэлийг бууруулах, аюулгүй амьдрах ухаан, зан үйлийн талаар олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулсан байх | | | |
| 3.6 | Гамшгаас хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллагыг түшиглэн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалыг хэрэглэгч, олон нийтийн оролцоотой боловсруулах, гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний ажлыг орчин үеийн техник, технологийг ашиглан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гүйцэтгэх | БСШУЯ, ОБЕГ | ШУА, иргэний нийгмийн байгууллага | 2016-2018 | 13 | Эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллагатай гамшгаас хамгаалах хамтын ажиллагаа сайжирсан байх | | 8 | Гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний ажлын цар хүрээ өргөжсөн байх |
| | | | | | 14 | Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалыг эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллагын туслалцаатайгаар олон нийтийн оролцоонд тулгуурлан боловсруулсан байх | | | |
| 3.7 | Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, үнэлж дүгнэх аргачлалыг хэрэглэгч, олон нийтийн оролцоотой боловсруулж хэрэгжүүлэх | ОБЕГ | ШУА | 2016-2020 | 15 | Олон нийтийн оролцоонд тулгуурлан төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх аргачлал боловсруулсан байх | 2021-2025 | 9 | Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд олон нийтийн зүгээс тавих хяналтын тогтолцоо бүрдсэн байх |
| | | | | | 16 | Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд иргэдийн тавих хяналтын механизмыг бүрдүүлсэн байх | | | |

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч | Хугацаа, хүрэх үр дүн | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | I үе шат 2016-2020 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | | II үе шат 2021-2025 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | |
| 3.8 | Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг тухайн орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй уялдуулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах. | ОБЕГ | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэний нийгмийн байгууллага | 2016-2020 | 17 | Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь эрсдэлийн үнэлгээнд тулгуурлаж боловсруулагдсан байх | | 10 | Олон нийтийн оролцоонд тулгуурлаж орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг хийдэг болсон байх |
| | | | | | 18 | Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгасан байх | | | |
| | | | | | 19 | Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө 80-аас доошгүй хувь шинэчлэгдсэн байх | | | |
| | | | | | 20 | Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь орон нутгийн онцлогт тохирсон, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр төлөвлөгдсөн байх, | | | |
| Дөрөв.**"Уур амьсгал, ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг шуурхай мэдээлэх тогтолцоог бэхжүүлэх"** зорилтын хүрээнд | | | | | | | | | |
| 4.1 | Уур амьсгал, ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлээс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг зайнаас тандан судлах, эрт илрүүлэх, эртнээс сэрэмжлүүлэх чадавхийг бэхжүүлэх | ХХААЯ, УЦУОШГ, ШУА | БОНХАЖЯ, ОБЕГ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэний нийгмийн болон ААНБайгууллага | 2016-2020 | 1 | Ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлээс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг зайнаас тандан судлах, эрт илрүүлж сэрэмжлүүлэх төвүүдийг 5 бүсийн хэмжээнд байгуулсан байх | | 1 | Орон нутаг, бүсийн хэмээнд байгалийн аюулт үзэгдлийг зайнаас тандан судлах, эрт илрүүлэх чадавх бүрдсэн байх. |
| | | | | | 2 | Зайнаас тандан судлах, эрт илрүүлж сэрэмжлүүлэх төвүүдийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлсэн байх | | | |

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч | Хугацаа, хүрэх үр дүн | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | I үе шат 2016-2020 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | | II үе шат 2021-2025 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | |
| 4.2 | Газар ашиглалт, бэлчээрийн нөхцөл байдлыг сансрын болон зайнаас тандан судлах технологийг ашиглан судлах, үр дүнг холбогдох төр, захиргааны байгууллага, иргэд, малчдад түгээх | ХХААЯ, УЦУОШГ | БОНХАЖЯ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга | 2016-2020 | 3 | Сансрын болон зайнаас тандан судлах технологийг ашиглан газар ашиглалт, бэлчээрийн нөхцөл байдлын талаар судалгаа хийгдсэн байх | 2021-2025 | 2 | Иргэд, малчид судалгаа, мэдээллийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашигладаг болсон байх |
| | | | | | 4 | Судалгааны үр дүнг олон нийтэд хүргэсэн байх | | | |
| Тав. **"Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоо, идэвх, санаачилгыг дэмжих"** зорилтын хүрээнд | | | | | | | | | |
| 5.1 | Ногоон бүсийг хамгаалах, ойжуулах, ойг нөхөн сэргээх болон ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, усны эх үүсвэрийг хамгаалах, цөлжилтийг сааруулах үйл ажиллагаанд хэрэглэгч, олон нийтийн оролцоог дэмжих | БОНХАЖЯ, ХХААЯ | ОБЕГ, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэний нийгмийн болон ААНБайгууллага | 2016-2020 | 1 | Олон нийтийн идэвх оролцоонд тулгуурлан ойг нөхөн сэргээх, усны эх үүсвэрийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байх | 2021-2025 | 1 | Ойн сан, ногоон байгууламжийн эзлэх хувь нэмэгдсэн байх |
| | | | | | 2 | Ойн нөхөрлөлүүдийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь дэмжсэн байх | | | |
| | | | | | 3 | Ойн сан бүхий газар нутгийг хамгаалах зорилгоор малчид, иргэд, ойн нөхөрлөлүүдэд гэрээгээ эзэмшүүлсэн байх | | 2 | Цөлжилт өмнөх жилүүдээс буурсан байх |
| | | | | | 4 | Цөлжилтийг сааруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгийн хэмжээнд тодорхой ажил зохион байгуулсан байх | | | |
| 5.2 | Орон нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлүүдэд байгаль, цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээлэл ашиглах, аюулт үзэгдэл тохиолдсон үед өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | ОБЕГ, УЦУОШГ | БОНХАЖЯ, ХХААЯ, ЭМСЯ аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга иргэний нийгмийн болон ААНБайгууллага, иргэд | 2016-2020 | 5 | Орон нутгийн иргэд, нөхөрлөлүүдэд жил бүр сургалт зохион байгуулагдсан байх | 2021-2025 | 3 | Иргэдийн гамшгаас хамгаалах ойлголт нэмэгдэж, гамшгийн хохирол буурсан байх |
| | | | | | 6 | Сургалт нь цаг үеэ олсон, зорилтод хэсэг рүү чиглэсэн, олон нийтийг хамарсан байх | | | |
| | | | | | 7 | Иргэд, нөхөрлөлүүдийн гамшгаас хамгаалах мэдлэг, чадавх сайжирсан байх | | 4 | Хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо нэмэгдсэн байх |
| 5.3 | Байгаль хамгаалах нөхөрлөлүүдэд гамшгийн эрсдэлийг бууруулах сургалт, | БОНХАЖЯ ОБЕГ | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга иргэний нийгмийн | 2016-2020 | 8 | Байгаль хамгаалах нөхөрлөлүүдэд гамшгийн эрсдэлийг бууруулах талаар | | 5 | Байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн уур амьсгалын өөрчлөлтөөс |

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч | Хугацаа, хүрэх үр дүн | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | I үе шат 2016-2020 он | | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | II үе шат 2021-2025 он | | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн |
| | сурталчилгааны ажлыг зохион байгуулах, бэлэн байдлын төлөвлөгөөтэй болгох, чадавхижуулах | | байгууллага | | | жил бүр сургалт явуулсан байх | | | үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах үүрэг, оролцоо нэмэгдсэн байх |
| | | | | | 9 | Байгаль хамгаалах нөхөрлөлүүд нь бэлэн байдлын төлөвлөгөөтэй болсон байх | | | |
| | | | | | 10 | Байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн бэлэн байдал, чадавх дээшилсэн байх | | | |
| Зургаа. **“Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг бэхжүүлэх”** зорилтын хүрээнд | | | | | | | | | |
| 6.1 | Нутгийн иргэд, иргэний нийгмийн болон аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотойгоор гамшгаас хамгаалах бэлэн байдал, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах ажиллагааг шуурхай зохион байгуулах арга хэмжээг боловсронгуй болгох, шинээр нэвтрүүлэх | ОБЕГ | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэний нийгмийн болон ААНБайгууллага, иргэд | 2016-2020 | 1 | Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангахад нутгийн иргэд, иргэний нийгмийн болон аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог хангасан байх | | 1 | Орон нутгийн гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, халдвар хамгаалалтын хувцас хэрэгслийн хүртээмж сайжирч, нөөц бүрдсэн байх |
| | | | | | 2 | Эрэн хайх, аврах ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог хангасан байх | | | |
| | | | | | 3 | Орон нутгийн айл өрх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын гамшгаас хамгаалах бэлэн байдал дээшилж, нөөц бүрдсэн байх | | 2 | Гамшгийн бэлэн байдлыг хангах, эрэн хайх аврах, хор уршгийг арилгах ажиллагаанд олон нийтийн оролцоо нэмэгдсэн байх |
| 6.2 | Хот, суурин газрын үерийн хамгаалалтын далан суваг, инженерийн байгууламжийг нэмэгдүүлэхэд хэрэглэгч, олон нийтийн оролцоог хангах | БХБЯ, Аймаг, нийслэлийн Засаг дарга, | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга,иргэний нийгмийн болон ААНБайгууллага | 2016-2020 | 4 | Суурин газрын үерийн хамгаалалт, инженерийн байгууламжийг барихад хувийн хэвшлийн оролцоо нэмэгдсэн байх | 2021-2025 | 3 | Хот, суурин газарт үерийн улмаас учрах аюул буурч, иргэдийн аюулгүй амьдрах орчин бүрдсэн байх |
| | | | | | 5 | Суурин газрын үерийн хамгаалалт, инженерийн байгууламжийг нэмэгдсэн байх | | | |
| 6.3 | Мэргэжлийн байгууллагуудын судалгаанд үндэслэн орон нутгийн удирдлага, иргэд, хэрэглэгч, олон нийтийн байгууллагын тусламжтайгаар | ОБЕГ, БОНХАЖЯ, БХБЯ | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ААНБ, иргэний нийгмийн байгууллага, | 2016-2020 | 6 | Орон нутгийн газар хөдлөлт, үерийн аюулын эрсдэлийн үнэлгээ, зураглал хийгдсэн байх | | 4 | Орон нутгийн дэд бүтцийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд гамшгийн эрсдэлийг тооцдог болсон байх |
| | | | | | 7 | Мэргэжлийн байгууллагуудын | | | |

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч | Хугацаа, хүрэх үр дүн | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | I үе шат 2016-2020 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | | II үе шат 2021-2025 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | |
| | газар хөдлөлт, үерийн аюулын эрсдэлийн зураглалыг боловсруулах | | иргэд | | | судалгаанд үндэслэн газар хөдлөлт, үерийн эрсдэлийн зураглал хийгдсэн байх | | 5 | Иргэдийн аюулгүй амьдрах нөхцөл бүрдсэн, үерийн аюулын эрсдэл буурсан байх |
| | | | | | 8 | Орон нутгийн удирдлага, иргэд олон нийтийн байгууллагын оролцоог хангасан байх | | | |
| 6.4 | Хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуй, газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, малчид, иргэдийн аж ахуй эрхлэх арга барил, технологийг сайжруулах замаар тэдгээрийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг бэхжүүлэх | ХХААЯ, УЦУОШГ | БОНХАЖЯ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга | 2016-2020 | 9 | Мал аж ахуй, газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, малчид, иргэдийн аж ахуй эрхлэх арга барил, технологи сайжирсан байх | 2021-2025 | 6 | Мал аж ахуй, газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, малчид, иргэдийн гамшгаас хамгаалах чадавх бэхжсэн байх |
| | | | | | 10 | Мал аж ахуй, газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, малчид, иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавх сайжирсан байх | | | |
| 6.5 | Цаг агаарын мэдээ, сэрэмжлүүлгийг харилцаа холбооны хэрэгслээр иргэд, олон нийтэд үнэ төлбөргүй, шуурхай хүргэх боломжийг нэмэгдүүлэх | БОНХАЖЯ, МТШХХГ, УЦУОШГ | ОБЕГ, ХХААЯ, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ААНБ, иргэний нийгмийн байгууллага | 2016-2018 | 11 | Цаг агаарын мэдээ, сэрэмжлүүлэг нь шинжлэх ухааны үндэстэй, үнэн зөв, хүртээмжтэй байх | | 7 | Уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын гаралтай гамшигт үзэгдлээс учрах эрсдэл буурсан байх |
| | | | | | 12 | Малчид, иргэд цаг агаарын сэрэмжлүүлэг, мэдээг шуурхай хүлээн авдаг боломж бүрдсэн байх | | | |
| 6.6 | Ой, хээрийн түймрийг тандах хяналтын тогтолцоог байгуулах, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, түймрээс хамгаалах зурвас татах ажлыг ойн нөхөрлөл, иргэдтэй хамтран зохион байгуулах | ОБЕГ | БОНХАЖЯ, МХЕГ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ААНБ, иргэний нийгмийн байгууллага, иргэд | 2016-2025 | 13 | Байгаль орчин, гамшгийн асуудал хариуцсан ажилтны ажиллах нөхцөл, боломжийг хангасан байх | 2021-2025 | 8 | Ой, хээрийн түймрийг тандах орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлсэн байх |
| | | | | | 14 | Малчид, иргэд, ойн нөхөрлөлүүдэд ой бүхий газрыг гэрээгээр эзэмшүүлж хяналт тавих боломжийг бий болгосон байх | | 9 | Ой, хээрийн түймрийн урьдчилан сэргийлэх, тэмцэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн төсөв, гамшгаас хамгаалах санд төвлөрүүлсэн байх |
| | | | | | 15 | Ой, хээрийн түймрээс хамгаалах талаар эрх бүхий байгууллагаас тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх | | | |
| | | | | | | | | 10 | Ой, хээрийн түймрийн |

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч | Хугацаа, хүрэх үр дүн | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | I үе шат 2016-2020 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | | II үе шат 2021-2025 он | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | |
| | | | | | 16 | Түймрээс хамгаалах зурвас татах хөрөнгийг жил бүр төсөвт тусгаж, эрсдэл бүхий газар, нутагт зурвас татсан байх | | | гаралт, хохирлын хэмжээ олон жилийн дунджаас буурсан байх |
| 6.7. | Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас шинээр болон дахин сэргэж байгаа халдварт өвчин, тэдгээрийн халдварын мониторингийн сүлжээг бий болгох, мэдээллийн сан бүрдүүлж, сургалт сурталчилгааг зохион байгуулах, | ЭМСЯ, ХХААЯ, МХЕГ | ОБЕГ, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга сумын болон сум дундын ойн анги, шинжлэх ухааны болон иргэний нийгмийн байгууллага | 2016-2020 | 17 | Шинээр болон дахин сэргэж байгаа халдварт өвчин, түүний тархалтын талаар судалгаа хийгдсэн байх | | 11 | Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас шинээр болон дахин сэргэж байгаа халдварт өвчний мониторингийн сүлжээг бий болгосон байх |
| | | | | | 18 | Шинээр болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс хүн, мал, амьтныг хамгаалах, сэрэмжлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж хэвшсэн байх | | | |
| | | | | | 19 | Шинээр болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгааг зохион байгуулсан байх | | 12 | Шинээр болон дахин сэргэж буй халдварт өвчин, тэдгээрийн халдварлалт буурсан байх. |
| | | | | | 20 | Шинээр болон дахин сэргэж байгаа халдварт өвчний мэдээллийн санг бий болгосон байх | | | |
| 6.8. | Хортон шавж, мэрэгчдийн тархалтын мониторингийн сүлжээг бий болгох, мониторингийн судалгаа хийх, мэдээллийн сан бүрдүүлж, сургалт сурталчилгааг зохион байгуулах | ХХААЯ, МХЕГ | БОНХАЖЯ, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, сумын болон сум дундын ойн анги, шинжлэх ухааны болон иргэний нийгмийн байгууллага | 2016-2020 | 21 | Хортон шавж, мэрэгчдийн тархалтын талаар судалгаа, шинжилгээ хийгдсэн байх | | 13 | Хортон шавж, мэрэгчдийн тархалтын мониторингийн сүлжээг бий болгосон байх |
| | | | | | 22 | Хортон шавж, мэрэгчдээс ойн сан, бэлчээрийг хамгаалах, арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх | | | |
| | | | | | 23 | Хортон шавж, мэрэгчдээс ойн сан, бэлчээрийг хамгаалах сургалт, сурталчилгааг зохион байгуулсан байх | | 14 | Хортон шавьж, мэрэгчдийн тархалттай тэмцэх чадавхи нэмэгдсэн байх |
| | | | | | 24 | Хортон шавж, мэрэгчдийн тархалтын мэдээллийн сантай болсон байх | | | |

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч | Хугацаа, хүрэх үр дүн<br>I үе шат 2016-2020 он | | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | II үе шат 2021-2025 он | | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6.9. | Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгаль экологийн нөлөөллийн үнэлгээг хэрэглэгч, олон нийтийн оролцоонд түшиглэн тусгайлсан бүс нутаг, газрын хэмжээнд гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх | БОНХАЖЯ, УЦУОШГ | ОБЕГ, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ААНБ, шинжлэх ухааны болон иргэний нийгмийн байгууллага | 2016-2020 | 25 | Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгаль экологийн нөлөөллийн талаар олон нийтэд хүргэсэн байх | | 15 | Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгаль экологийн нөлөөллийг бууруулах талаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх |
| | | | | | 26 | Байгаль экологийн нөлөөллийн үнэлгээг олон нийтийн оролцоонд тулгуурлан хийсэн байх | | | |
| | | | | | 27 | Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгаль экологийн нөлөөллийн мэдээллийн сантай болсон байх | | 16 | Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгаль экологид нөлөөлөх эрсдэлийг бууруулсан байх |
| 6.10. | Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгаас хамгаалах талаар ном, гарын авлага, заавар, зөвлөмж боловсруулах, сургалт, семинар, эрдэм шинжилгээний хурал, сурталчилгааны ажил зохион байгуулах | БОНХАЖЯ, ОБЕГ | БСШУЯ, аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг дарга, ААНБ, шинжлэх ухааны болон иргэний нийгмийн байгууллага, иргэд | 2016-2020 | 28 | Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгаас хамгаалах талаар ном, сурах бичиг, гарын авлага, заавар, зөвлөмж боловсруулж гаргасан байх | 2021-2025 | 17 | Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах талаар төрийн бодлого, хөгжлийн төлөвлөлтөд тусгаж, тодорхой арга хэмжээг авч хэрэгүүлсэн байх |
| | | | | | 29 | Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгаас хамгаалах талаар уулзалт, семинар, эрдэм шинжилгээний хурал 3-аас доошгүй удаа зохион байгуулсан байх | | | |
| | | | | | 30 | Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгаас хамгаалах талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулсан байх | | | |

--ooOoo--